

Golomt Capital®

Валютын зах зээлийн ТОЙМ

ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК- Д БЭЛТГЭВ

2022.06.13

*Дотоодын зах зээл
Олон улсын зах зээл*

ДОТООДЫН ВАЛЮТЫН ЗАХ ЗЭЭЛИЙН СУУРЬ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2022 он 06 сарын 13

Ханшийн өөрчлөлт	Албан ханш	Долоо хоног	Оны эхнээс	Жил
	3,121.03	0.016%	9.548%	9.556%

Товч дүгнэлт:

Өнгөрсөн долоо хоногт ам.долларын ханш төгрөгийн эсрэг 0.017 хувиар чангарлаа. АНУ-ын 5 сарын инфляцын түвшин сүүлийн 40 жилийн дээд түвшиндээ хүрснээр арилжаачдад холбооны нөөцийн сан бодлогын хүүгээ 75 нэгжээр нэмэгдүүлж магадгүй гэсэн хардлагыг төрүүлснээр ам.долларын ханш бусад валютуудын эсрэг чангарлаа.

Монголбанкны дуудлага худалдаа:

Өнгөрсөн долоо хоногт Монголбанк банкнуудын 60 сая ам.доллар худалдан авах хүсэлтийг зах зээлд нэг ханшаар нийлүүлсэн байна. Харин банкууд 10 сая ам.долларын своп хэлцэл байгуулах саналыг 2 удаа ирүүлсэн бол Монголбанк ирүүлсэн саналыг биелүүлээгүй байна.

**Гадаад худалдаа:**

2022 оны эхний 5 сарын байдлаар Монгол Улсын гадаад худалдааны эргэц өмнөх оноос 21.9 хувиар өсч 7221 сая ам.долларт хүрсэн бол экспорт 22 хувиар өсөж 4083 сая ам.доллар импорт 20 хувиар өсч 3137 сая ам.долларт хүрсэн байна. Ингэснээр 2022 оны эхний 5 сарын байдлаар цэвэр экспорт 947 сая ам.доллар хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 31 хувиар өссөн байна..



Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

ОЛОН УЛСЫН ВАЛЮТЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2022 оны 6-р сарын 13

	Хаалтын ханш	7 хоног	1 сар	1 жил
DXY	104.395	2.21%	-2.37%	15.05%
EURUSD	1.0483	-1.95%	0.71%	-13.48%
USDCNY	6.7398	1.24%	-0.77%	5.3%
USDRUB	56.8	-6.91%	-12.00%	-21.22%
USDJPY	134.8	2.24%	4.36%	22.50%
AUDUSD	0.7010	-2.52%	1.02%	-9.09%

DXY ханшийн хөдөлгөөн:

Өнгөрсөн долоо хоногт ам.долларын ханш олон улсын зах зээл дээр голлох валютуудын эсрэг чангарах хөдөлгөөн үзүүлээ. Ханшийн өөрчлөлтөд дараах хүчин зүйлс голлон нөлөөллөө.

- Өнгөрсөн долоо хоногийн баасан гарагт АНУ-ын 5 сарын хэрэглээний үнийн индексийн тоон мэдээлэл гарлаа. 5 сард хэрэглээний үнийн индекс 8.6 хувь буюу сүүлийн 40 жилийн хамгийн өндөр үнийн өсөлттэй гарлаа. Арилжаачид болон хөрөнгө оруулагчдын дунд тус мэдээлэлтэй холбоотой АНУ-ын холбооны нөөцийн сан бодлогын хүүг 75 суурь нэгжээр нэмэгдүүлэх төлөвтэй байгаа гэсэн айдас үүсээд байна.
- 2022 оны 06 сарын 16 өдөр буюу энэ долоо хоногийн пүрэв гарагт АНУ-ын холбооны нөөцийн сан бодлогын хүүгийн шийдвэрээ гаргана. ХНС-ийн тэргүүн Jerome Powell бодогын хүүг 50 нэгжээр нэмэгдүүлнэ гэдэг амлалтыг өгөөд байсан бол ХҮИ төсөөллөөс өндөр гарсан учир бодлогын хүүг хэдэн нэгжээр нэмэгдүүлэх нь тодорхойгүй байна.

График 3 : DXY /ам.долларын индекс/-ийн 7 хоногийн лаа



Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.